

МОНГОЛ УЛС
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ
ТОГТООЛ

2003 оны 3 дугаар
сарын 21 ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар
хот

Журам, заавар батлах тухай

“Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 34.1.3 дахь заалтыг үндэслэн Үнэт цаасны хорооноос ТОГТООХ нь:

1. “Тендер санал гаргах, дүгнэх тухай” журам, “Компани өөрийн үнэт цаасыг худалдан авах, худалдах, бүртгэх тухай” журам, “Үнэт цаасны брокер, дилерийн компанид захиалгын гэрээ, захиалгын бүртгэл, дилерийн даалгаврын гэрээний Маягтыг хөтлөх заавар” –ыг хавсралтаар тус тус баталсугай.
2. Дээрх журам, зааврыг шинэчлэн батлагдсантай холбогдуулан 1996 оны 2 дугаар сарын нэгний 09 дүгээр тогтоолоор баталсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаас, тендер саналыг сурталчлах тухай”, 1995 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 6 дугаар тогтоолоор баталсан “Тендер санал гаргах, түүнтэй холбогдох үйл ажиллагааг зохицуулах тухай” 1996 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 107 дугаар тогтоолоор баталсан “Сангийн хувьцааг худалдан авах, худалдах, бүртгэх тухай” 1996 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 14-р тогтоолоор баталсан “Брокер-дилерийн үйл ажиллагаа явуулах үнэт цаасны компани болон МХБ-д анхан шатны бүртгэлийн маягт хөтлөх тухай” журмыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
3. Шинэчлэн баталсан журам, зааврыг үнэт цаасны зах зээлд оролцогч этгээд болон мэргэжлийн байгууллагуудад сурталчлан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Ажлын алба / Ж.Жадамбаа/-нд даалгасугай.

ДАРГА

С.ГҮНДЭНБАЛ

Монгол улсын Үнэт цаасны хорооны
2003 оны 3 дугаар сарын 21-ний
өдрийн 20 дугаар тогтоолын хавсралт

КОМПАНИ ӨӨРИЙН ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ, ХУДАЛДАХ, БҮРТГЭХ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. “Компанийн тухай” хуульд өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн худалдан авах талаар заасан 34.5; 50; 51; 53; 54; 55 дугаар заалтуудыг хэрэгжүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Компанийн өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр, “Компанийн тухай” хуулийн холбогдох заалтуудыг үндэслэн худалдан авсныг халаасны хувьцаа гэж тооцно. Халаасны хувьцаа нь тухайн компанийн гүйлгээнээс гаргасан хувьцаа учраас саналын болон ногдол ашгийн эрхгүй.

ХОЁР. Компани хувьцаагаа худалдан авах, худалдах

2.1. Компанийн анх гаргасан хувьцаа худалдагдсаны дараа компани өөрийн хувьцааг худалдан авч болно.

2.2. Компанийн халаасны хувьцааг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, компанийн эрх бүхий албан тушаалтанд худалдах бол энэ нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдоно. Ийм хэлцлийг Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасан журмын дагуу хийнэ.

2.3. Халаасны хувьцааг худалдаж авах, худалдах шийдвэр гаргах үед зах зээлийн ханшаар тооцсон үнийн дүн нь хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активийн нийт дүнгийн 25 хувиас дээш байвал энэ нь их хэмжээний хэлцэлд тооцогдоно.

Их хэмжээний хэлцлийг Компанийн тухай хуулийн 85 дугаар зүйлд заасан журмын дагуу хийнэ.

2.4. Компани өөрийн хувьцааг худалдан авах, худалдах тухай асуудлыг хувь нийлүүлэгчдийн хурлаар шийдвэрлэнэ.

2.5. Халаасны хувьцаа худалдан авах, худалдах асуудлыг хэлэлцсэн хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрт худалдан авах, худалдах хувьцааны тоо, хэмжээ, төлбөр хийх хугацаа, зориулалт, худалдан авах хөрөнгийн эх үүсвэрийг тодорхой заасан байна.

2.6. Хувь нийлүүлэгчдийн хурлаар баталсан компанийн дүрэмд халаасны хувьцааг худалдан авах, худалдах асуудлыг шийдвэрлэх эрхийг компанийн төлөөлөн удирдах зөвлөлд олгохоор заасан бол энэхүү журмын 5 дахь заалтад холбогдох шийдвэрийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл гаргах эрх эдэлнэ.

2.7. Халаасны хувьцаа болгон эргүүлэн худалдан авах энгийн хувьцааны тоо, хэмжээ нь уг хувьцаат компанийн тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дундаж хэмжээний 25 хувиас хэтэрч болохгүй.

2.8. Халаасны хувьцаа худалдан авахаар гаргасан хувь нийлүүлэгчдийн эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг Үнэт цаасны хороо, Хөрөнгийн бирж, хувьцаагаа худалдан авахад зуучлах үнэт цаасны компаниудад шийдвэр гарснаас хойш ажлын 7 хоногт багтаан хүргүүлнэ.

2.9. Халаасны хувьцаа худалдан авахад зуучлах Брокер, дилерийн компани нь Хөрөнгийн биржийн төвлөрсөн хадгаламжид хувьцаат компанийн данс нээлгэх захиалгыг хүргүүлэх, халаасны хувьцаа худалдан авах, худалдах захиалгыг хүлээн авч биелүүлэхдээ энэхүү журмын 5 ба 6 дугаар зүйлд заасан хурлын шийдвэрийг үндэслэнэ.

2.10. Хувьцаат компанийн төвлөрсөн хадгаламж дахь дансыг тухайн хувьцаат компанийн нэр дээр нээх бөгөөд уг дансад гүйлгээ хийх захиалга өгөх итгэмжлэгдсэн этгээдийг компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн гүйцэтгэх захирлын тушаалаар томилно. Нотариатаар батлуулсан итгэмжлэгдсэн этгээдийн гарын үсгийн баталгаа зуучлагч Брокер, дилерийн компанид хадгалагдана. Хэрэв хэд хэдэн Брокер, дилерийн компаниар зуучлуулж байгаа бол компани бүрт баталгаа хадгалагдана.

2.11. Итгэмжлэгдсэн этгээдийн итгэмжлэлийн хугацаа дууссан, ажлаас гарсан болон бусад шалтгаанаар итгэмжлэгдсэн этгээд өөрчлөгдсөн тохиолдолд Хувьцаат компани нь зуучлагч Брокер, дилерийн компаниуд болон Хөрөнгийн биржид мэдээлэх бөгөөд хугацаанд нь мэдээлээгүйгээс итгэмжлэлгүй этгээдийн хийсэн хэлцлээс учирсан хохирлыг Брокер, дилерийн компани, Хөрөнгийн бирж хариуцахгүй.

ГУРАВ. Халаасны хувьцааны бүртгэл, тайлан

3.1. Халаасны хувьцаа худалдан авсан тохиолдолд Мөнгөн хөрөнгийн дансны кредитээс халаасны хувьцааны дансны дебетэд нэрлэсэн үнээр нь бүртгэнэ.

3.2. Компани хувьцаагаа худалдсан тохиолдолд халаасны хувьцааны кредитээс Мөнгөн хөрөнгийн дансны дебетэд бичнэ.

3.3. Нэрлэсэн үнэ болон худалдан авсан үнэ хоёрын зөрүүг нэмэгдэж төлөгдсөн капиталын дансад тусгана.

3.4. Худалдан авахтай холбогдсон зардал нь/Брокер, дилерийн компани, Хөрөнгийн биржид төлсөн шимтгэл болон бусад/ үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хамаарна.

3.5. Халаасны хувьцааг тайлан балансад Эзэмшигчийн өмчийн хэсэгт хасах тэмдэгтэйгээр оруулна.

ДӨРӨВ. Журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

4.1. Энэхүү журмын 2 дугаар хэсгийн 4-11 дүгээр заалт, 3 дугаар хэсгийн 13, 14 дүгээр заалтыг зөрчсөн албан тушаалтанд “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу захиргааны шийтгэл ногдуулна.

4.2. Захиргааны энэхүү шийтгэлийг ногдуулах эрхийг “Захиргааны хариуцлагын тухай” хуулийн 7 дугаар зүйлд зааснаар Үнэт цаасны гүйлгээний хяналтын улсын байцаагчид эдэлнэ.